



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2024 оны 01 сарын 30 өдөр

Дугаар А/ЧД

Улаанбаатар хот

Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх болон хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.20.6 дахь заалт, Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1, 6.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.1, 6.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1, 1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 сарын хугацаанд түдгэлзүүлэх болон хүчингүй болгох байгууллагын нэрсийг хавсралтаар баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Төгсдэлгэрт даалгасугай.

САЙД



С.ЧИНЗОРИГ

141240315

Эрүүл мэндийн сайдын 2024 оны  
01 дүгээр сарын 30 өдрийн 4/НО  
дугаар тушаалын хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА ӨРХЛЭХ ТУСГАЙ  
ЗӨВШӨӨРЛИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ БОЛОН ХҮЧИНГҮЙ БОЛГОХ  
БАЙГУУЛЛАГЫН ЖАГСААЛТ

№	Байгууллагын нэр	Тусгай зөвшөөрлийн төрөл, чиглэл	Хаяг, байршил
Нэг. Тусгай зөвшөөрлийг 3 сарын хугацаанд түдгэлзүүлэх			
1	“Мөнх чулуут өндөр” ХХК	Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, протез үйлдвэрлэх, импортлох, ханган нийлүүлэх, засвар үйлчилгээ эрхлэх	Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 18-р хороо, Манлайбаатар Дамдинсүрэнгийн гудамж, 25/3
Хоёр. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох			
1	“Дэвшил баян фарм” ХХК	Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, протез үйлдвэрлэх, импортлох, ханган нийлүүлэх, засвар үйлчилгээ эрхлэх	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 10 дүгээр хороо “Эмон Бизнес” төвийн 2 давхар, 201 тоот
2	Эрхэм чанар-Эрдэнэ ХХК	Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, протез үйлдвэрлэх, импортлох, ханган нийлүүлэх, засвар үйлчилгээ эрхлэх	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, 11-р хороолол, 3,29